



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 03 сарын 26 өдөр

Дугаар 96

Улаанбаатар хот

“Гэр даатгал” ХХК-ийн хувь нийлүүлэгчдийн
бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 21.5 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Гэр даатгал” ХХК-ийн хувь нийлүүлэгч А.Гансүхийн өмчлөлийн нэг ширхэг нь 1000 /нэг мянган/ төгрөгийн үнэ бүхий 1,100,500 ширхэг буюу 1,100,500,000 /нэг тэрбум нэг зуун сая таван зуун мянган/ төгрөгийн хувьцааг тус компанийн хувь нийлүүлэгч “Вектор интэрнэшнл” ХХК-д худалдаж, хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд дараах байдлаар өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.

	Хувь нийлүүлэгч	Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь /%/
		Эхний үлдэгдэл	Өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл	
1	“Вектор Интэрнэшнл” ХХК	899,500,000.0	1,100,500,000.0	2,000,000,000.0	100
2	Иргэн А.Гансүх	1,100,500,000.0	(1,100,500,000.0)	0.0	0.0
	Нийт	2,000,000,000.0		2,000,000,000.0	100

2. Хувь нийлүүлэгчдийн бүтцэд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон Улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг 2014 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Гэр даатгал” ХХК /Г.Баттогтох/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000000